sendmn

Сэнд Эм Эн ББСБ ХХК

Үйл ажиллагааны тайлан

Мөнгөн гуйвуулгыг гэрлийн хурдаар

2025

Агуулга

Энэхүү тайланд Сэнд Эм Эн ББСБ ХХК-ийн 2025 оны үйл ажиллагаа, компанийн засаглал, нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлыг товч танилцуулж байна.

2025 онд товчхондоо 3

Санхүүгийн болон бусад гол үзүүлэлт

Зорилт, онцлох үйл явдлууд 4

2025 оны 7 зорилт
Онцлох үйл явдлууд

Компанийн тухай 5

Эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс
Шагнал, үнэлгээ
Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Компанийн засаглал 7

Төлөөлөн удирдах зөвлөл
Эрсдэл, дотоод аудит
Мэдээллийн аюулгүй байдал, БОНЗ

Хамт олон 10

Жендерийн тэгш байдал, ажилтны оролцоо
Сургалт, хөгжил
Эрүүл мэнд, хөнгөлөлт, хангамж

Нийгмийн хариуцлага 13

Хандив, дэмжлэг
Түншлэл, хамт олон

Оролцогч талуудын эрх ашиг 15

Харилцагчийн үйлчилгээ

2025 онд товчхондоо

Сэнд Эм Эн ББСБ ХХК-ийн 2025 оны үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд.

Нийт гуйвуулга	**1.4** их наяд төгрөг
Валют арилжаа	**90** тэрбум төгрөг
Зээлийн багц	**8.2** тэрбум төгрөг
Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө	**5.1** тэрбум төгрөг
Төлсөн татвар	**1.39** тэрбум төгрөг

Бусад гол үзүүлэлт

117,515
харилцагчийн хандалт хүлээн авч, 100% шийдвэрлэсэн

98.6%
СЗХ-ны 2024 оны Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ

57%
удирдах болон дунд шатны менежерүүдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь

82%
ажилтны оролцоо (engagement)

50+
ажилтнуудын хамрагдсан гадаад, дотоод сургалт

ISO/IEC 27001:2022
мэдээллийн аюулгүй байдлын стандартын шинэ хувилбарт бүрэн шилжсэн

Зорилт, онцлох үйл явдлууд

Бид 2025 онд 7 зорилт төлөвлөн хэрэгжүүлсэн. Онцлох үйл явдал бүрийн дэлгэрэнгүйг дугаарласан хуудаснаас үзнэ үү.

2025 оны зорилтууд

1. Монгол Улсын мөнгөн гүйвуулгын зах зээлд эзлэх байр сууриа тэлэх
2. СНГ-ийн орнууд руу мөнгөн гүйвуулгын үйл ажиллагаагаа тэлэх
3. SendMN аппликейшны хэрэглээг нэмэгдүүлж, олон улсаас ашиглах боломжтой болгох
4. Валют арилжааны үйл ажиллагааг тэлэх
5. Компанийн брендийн нэр хүндийг өсгөж, экспатын зах зээлд танигдах
6. Зээлийн үйл ажиллагааг өргөтгөж, эх үүсвэр татах
7. Компанийн нийгмийн хариуцлагыг сайжруулах

Онцлох үйл явдлууд

SendMN 3.0 6

Аппликейшны 5 жилийн ойгоор олон улсад ашиглах боломжтой шинэ хувилбарыг нэвтрүүлсэн.

ISO/IEC 27001:2022 9

Мэдээллийн аюулгүй байдлын стандартын шинэчилсэн хувилбарт бүрэн шилжсэн.

БОНЗ-ын бодлого 9

Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлогыг баталж, хэрэгжүүлж эхэлсэн.

ToC холбооны үндсэн гишүүн 9

Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоонд үндсэн гишүүнээр нэгдсэн.

Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн код 9

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санаачилсан олон улсын хөтөлбөрт албан ёсоор нэгдсэн.

Хилийн чанад дахь монголчууд 14

Хилийн Чанад дахь Монголчуудын Зөвлөл НҮТББ-тай урт хугацааны түншлэл эхлүүлсэн.

Frontier Fintech Summit 14

Монголын Финтекийн Холбооны гишүүний хувьд арга хэмжээг 2 дахь жилдээ ивээн тэтгэсэн.

Expat Night 14

Улаанбаатар дахь гадаад иргэдэд зориулсан анхны “Expat Night” арга хэмжээгээ зохион байгуулсан.

osTicket ба AI ажилтан 15

Харилцагчийн хүсэлт бүртгэх системийг нэвтрүүлж, AI ажилтны туршилтыг амжилттай хийсэн.

Компанийн тухай

Олон улсын мөнгөн гүйвуулгын финтек компани. Мөнгөн гүйвуулга, валют арилжаа, зээл, итгэлцэл, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлдэг.

Эрхэм зорилго

Дэлхий даяар тархан суурьшсан Монгол иргэдийн мөнгөн гүйвуулгын бүх асуудалд хамгийн хямд бөгөөд хамгийн хурдан шийдлийг санал болгоно.

Алсын хараа

Монгол Улсын үсрэнгүй хөгжилд хувь нэмрээ оруулсан, олон улсын түвшинд өрсөлдөхүйц мөнгөн гүйвуулгын компани байна.

Эрхэмлэх үнэт зүйлс

Үр дүн	Хариуцлага	Багийн ажиллагаа	Ил тод байдал

Шагнал, үнэлгээ

2022

Монгол Улсын шилдэг мөнгөн гүйвуулгын компани

2023

Шилдэг валют арилжааны байгууллага

2024

Зээлээс бусад үйлчилгээ үзүүлэгч шилдэг байгууллага

98.6%

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр 98.6 хувийн үнэлгээ авч, **итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ-уудаас тэргүүн байр** эзэлсэн.

Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Бид мөнгөн гуйвуулга, валют арилжаа, зээл, итгэлцэл, төлбөр тооцооны үйлчилгээг харилцагчдадаа, системийнхээ боломжийг бусад санхүүгийн байгууллагад санал болгодог.



SendMN аппликейшн

Мөнгөн гуйвуулга

SendMN аппликейшны 5 жилийн ойг тохиолдуулан олон улсад ашиглах боломжтой SendMN 3.0 хувилбарыг нэвтрүүлсэн.

Валют арилжаа

Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудал болон 8 валют арилжааны салбартай. SendMN апп-аар валютаа урьдчилан захиалж, нисэхээсээ өмнө салбараас дараалалгүй авах үйлчилгээг нэвтрүүлсэн.

Зээл

Хэрэглээний, бизнесийн, шуурхай гэсэн 3 төрлийн зээлийг харилцагчдадаа санал болгодог.

Итгэлцэл

Доллар болон төгрөгийн итгэлцлийг апп-аар дамжуулан хөрөнгө оруулагч, харилцагчдадаа өндөр өгөөжтэй санхүүгийн бүтээгдэхүүн болгон санал болгож байна.

Төлбөр тооцоо

Дотоодын нэхэмжлэлтэй болон нэхэмжлэлгүй төлбөр тооцоог SendMN апп-аар хийх боломжтой.

Нээлттэй ББСБ

Мөнгөн гуйвуулга болон валют арилжааны системийн боломжийг бусад санхүүгийн байгууллагуудад нээлттэйгээр санал болгодог.

Компанийн засаглал

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн засаглалын зарчим, сайн туршлагыг нэвтрүүлж, хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаална.

Төлөөлөн удирдах зөвлөл

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоож, эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсийн хүрээнд хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын хууль ёсны эрх ашгийн төлөө ажилладаг.

ТУЗ нь 6 гишүүн, 2 хараат бус гишүүн бүхий 8 гишүүний бүрэлдэхүүнтэй. ТУЗ-ийн дэргэд Эрсдэл, аудитын хороо болон БОНЗ-ын хороо ажилладаг.

ТУЗ үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос батлсан журам, заавар зэрэг Монгол Улсын хууль тогтоомж, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон компанийн дотоод эрх зүйн баримт бичгийг дагаж мөрддөг.



Г.Болор-Эрдэнэ
ТУЗ-ийн дарга



Б.Төрболд
ТУЗ-ийн гишүүн



Т.Банзрагч
ТУЗ-ийн гишүүн



Ч.Доржнамжил
ТУЗ-ийн гишүүн



Н.Гантулга
ТУЗ-ийн гишүүн



Г.Солонго
ТУЗ-ийн гишүүн



С.Цэнгэл
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Ч.Баяртуул
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Ц.Үндрах
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Эрсдэл, дотоод аудит

ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын алба нь Эрсдэл, аудитын хорооны шууд удирдлагад хараат бусаар ажиллаж, тайлагнадаг. Албаны 2025 оны төлөвлөгөөг компанийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээнд суурилан боловсруулж, ТУЗ-өөр батлуулсан.



2025 онд хийгдсэн аудит

- Санхүүгийн албаны үйл ажиллагаа болон 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан (санхүүгийн, нийцлийн, үйл ажиллагааны аудит)
- Сонирхлын зөрчилтэй болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийгдсэн хэлцлүүд (зээл, итгэлцэл, албан томилолт)
- Мэдээллийн технологийн алба болон Харилцагчийн үйлчилгээний албаны үйл ажиллагаа
- ISO/IEC 27001:2022 стандартын дагуу мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны дотоод аудит (хөндлөнгийн аудитын багтай хамтран)
- Нийцлийн аудит, дотоод журам болон БОНЗ-ын баримт бичгийн зөрүүгийн шинжилгээ

Аудит бүрийн тайлан, дүгнэлт, зөвлөмжийг удирдлагад хүргүүлж, хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацааны дагуу хянаж байна.

Залилангаас урьдчилан сэргийлэх

Компанийн “Залилангаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шалгах журам”-ыг боловсруулж, III улиралд ТУЗ болон Эрсдэл, аудитын хорооны хурлаар батлуулсан. Мөн дотоод системүүдийн хандах эрхэд нэмэлт хяналт, хязгаарлалт тогтоосон.

Сургалт

II улирал	Менежментийн багт “Залилангийн эрсдэл, түүнд тавигдах хяналт” сэдэвт сургалт
III улирал	Комплайнс, хүний нөөц, мэдээллийн аюулгүй байдлын ажилтнууд болон ахлах түвшний ажилтнуудад ижил сэдвээр сургалт
IV улирал	Нийт ажилтнуудад “Дотоод аудитын тухай” сургалт

Цаашид

Эрсдэлд суурилсан дунд хугацааны болон 2026 оны аудитын төлөвлөгөөг Эрсдэл, аудитын хорооны саналыг авч, 2025 оны 12-р сард ТУЗ-ийн хурлаар батлуулсан. Зөвлөх үйлчилгээний хүрээнд дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах ажлыг удирдлагатай хамтран хэрэгжүүлж байна.

Мэдээллийн аюулгүй байдал

ISO/IEC
27001

2023
Олон улсын ISO/IEC 27001 стандартыг нэвтрүүлсэн

2025
ISO/IEC 27001:2022 хувилбарт бүрэн шилжсэн

Бид мэдээллийн аюулгүй байдлын олон улсын ISO/IEC 27001 стандартыг 2023 онд нэвтрүүлж, 2025 онд шинэчилсэн ISO/IEC 27001:2022 хувилбарт бүрэн шилжсэн.

Энэхүү стандарт нь компанийн мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог дэлхийн жишигт нийцүүлж, учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, бууруулах, удирдах боломжийг бүрдүүлдэг.

Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)

Бид 2025 онд БОНЗ-ын бодлогоо баталж, үзэл баримтлал, санал санаачилгыг нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн.

Байгаль орчин

Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоонд (ТоС холбоо) үндсэн гишүүнээр нэгдсэн. Тогтвортой санхүүжилтийн зарчмыг үндсэн үйл ажиллагаандаа нэвтрүүлж, ногоон хөрөнгө оруулалт татах, байгальд ээлтэй төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр зорьж байна.

TML Plastic ХХК-тай гэрээ байгуулж, оффисын хог хаягдлыг ангилан хүлээлгэн өгч эхэлсэн.

Нийгэм

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санаачилсан “Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн код” олон улсын хөтөлбөрт албан ёсоор нэгдсэн нь жендерийн эрх тэгш байдлыг хангах томоохон алхам боллоо.

Засаглал

2025 онд БОНЗ-ын бодлогыг баталж, хэрэгжүүлж эхэлсэн.

ТУЗ-ийн дэргэд БОНЗ-ын хороо байгуулагдсан.



“Эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн код” хөтөлбөрт нэгдэв



ТоС холбоонд үндсэн гишүүнээр нэгдсэн



Оффисын хог хаягдлыг ангилж эхэлсэн

Хамт олон

Ажилтныхаа ажил амьдралын тэнцвэрийг хангаж, өндөр сэтгэл ханамжийг хадгалахыг зорьдог.

Жендерийн тэгш байдал

Бид жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн карьерын өсөлтийг дэмжихэд анхаарч ажилладаг. Удирдах болон дунд шатны менежерүүдийн 57% нь эмэгтэйчүүд байна.



Ажилтны сэтгэл ханамж, оролцоо

Ажилтны сэтгэл ханамж, үнэнч байдлыг 0–10 оноот шкалаар судалсан. Ажилтны үнэнч байдлын индекс (eNPS) нь 9–10 оноо өгсөн дэмжигчдийн хувиас 6 ба түүнээс доош оноо өгсөн эсэргүүцэгчдийн хувийг хассан үзүүлэлт юм.

34.1

Ажилтны үнэнч байдлын индекс (eNPS)



−100-аас +100 хүртэлх шкалаар “сайн” түвшинд үнэлэгдсэн.

82%

Ажилтны оролцоо (engagement)



Судалгааны үр дүнд компанийн хэмжээнд ажилтны оролцоо 82% гэж үнэлэгдсэн.

Сургалт, хөгжил

2025 онд манай ажилтнууд гадаад, дотоодын нийт 50 гаруй сургалтад хамрагдсан. Эдгээрийн 40 нь мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, 10 нь хүний хөгжлийн сургалт байв.

34

сая орчим төгрөг


сургалт, хөгжилд зарцуулсан

Сургалтын агуулга


40 мэргэжлийн ур чадвар **10** хүний хөгжил

Сургалтын төрөл

64% гадаад **36%** дотоод



Мэдээллийн аюулгүй байдлын сургалт, 2025



Хөдөлмөрийн дотоод журмын сургалт, 2025

Шинэчлэн батлагдсан журам

Цалин урамшууллын журам

Хүний нөөцийн бодлогын хүрээнд тэгш шударга, илтод зарчимд тулгуурласан шагнал урамшууллын тогтолцоогоор ажилтныг сэдэлжүүлэх зорилгоор шинэчлэн батлагдсан.

Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний журам

Өндөр бүтээмжтэй байгууллагыг цогцлоож, тасралтгүй суралцах соёлыг бий болгох үүднээс үнэт зүйлс, сургалт хөгжлийн үнэлгээнд тулгуурласан журмыг шинэчлэн батлагдсан.

Эрүүл мэнд, хөнгөлөлт, хангамж

Бид ажилтны ажил амьдралын тэнцвэрийг хангах, өндөр сэтгэл ханамжийг хадгалах зорилгоор дараах ажлуудыг хэрэгжүүлсээр байна.

Hugmom Mongolia

Сэтгэл зүйн төвтэй хамтран бүх ажилтнаа 1 цагийн үнэ төлбөргүй сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулсан.

Грандмед эмнэлэг

Бүх ажилтнаа жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулдаг уламжлалтай. 2025 онд 50 ажилтан бүтэн биеийн шинжилгээнд хамрагдсан.

Ажил амьдралын тэнцвэр

- 5 ба түүнээс дээш жил ажилласан ажилтанд сард нэг удаа цалинтай чөлөө
- Хичээлийн шинэ жилээр эцэг, эхчүүдэд бүтэн өдрийн цалинтай чөлөө
- Хүүхдийн баяраар ажилтнуудын хүүхдүүдэд зориулсан арга хэмжээг оффист зохион байгуулдаг
- Хүүхдийн баяраар хүүхэдгүй ажилтнуудад хагас өдрийн чөлөө
- 100 хувийн ирцтэй ажилласан ажилтанд цалинтай чөлөө
- Байгууллагын машиныг амралтын өдрөөр хотоос 100 км радиуст ашиглах боломж

Цалинтай чөлөө

Дотоод журамд тусгасан нөхцөлүүд

Ажилтан, ажилтны хүүхэд хурим хийх	**хотод 3, орон нутагт 5 ажлын өдөр**
Ажил явдал гарах	**хотод 3, орон нутагт 5 ажлын өдөр**
Шинэ аав	**10 ажлын өдөр**
Сургуулийн эргүүлийн үүрэг гүйцэтгэх	**хагас өдөр**
Ажилтан, ажилтны хүүхэд өвдөх (эмчийн магадлагаатай)	**1 хүртэл ажлын өдөр**
Төрсөн өдөр	**төрсөн сардаа 1 өдөр**

Бусад хөнгөлөлт, хангамж

- Уян хатан ажлын цаг: өвлийн улиралд долоо хоногт 1 өдөр гэрээсээ ажиллах
- Хоол, унааны мөнгө
- Сургалт хөгжлийн цогц систем
- Тав тухтай ажлын байр, амрах болон тоглоомын хэсэг
- Шинээр төрсөн хүүхдийн бэлэг, хуримын болон ахмад настны нэмэгдэл бүхий урамшуулал



Нийгмийн хариуцлага

Монгол дахь болон хилийн чанад дахь хамт олноо дэмжиж, нийгэмд хувь нэмрээ оруулсаар байна.



“Амьдрал бэлэглэе” аян

Монголын ББСБ-уудын холбооноос санаачилсан аянд нэгдэж, #ТомЗүрхийгБүтээе уриан дор 1200 хүнд амьдрал бэлэглэх үйлсэд оролцсон.



Хүчирхийллийн эсрэг үндэсний төв

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-д хандив гардуулав.



Veloo Foundation

Veloo Foundation-ийг 3 дахь жилдээ дэмжиж, хүүхдүүдэд аюулгүй, дулаан, баяр хөөрөөр дүүрэн орчин бүрдүүлэх ажилд хувь нэмрээ оруулаа.

“Старс” сагсан бөмбөгийн баг

“Шаравжамцстарс Сан”-гийн нэрэмжит эрэгтэй сагсан бөмбөгийн “Старс” багт санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Түншлэл, хамт олон

Хилийн чанад дахь монголчууд, Монголд амьдарч буй гадаад иргэд болон салбарын хамт олонтойгоо хамтран ажилласан.



Хилийн Чанад дахь Монголчуудын Зөвлөл

Хилийн чанадад амьдарч буй монголчуудын дунд үндэсний өв соёлыг түгээх, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор түс зөвлөлтэй урт хугацааны түншлэл эхлүүлж, гишүүн байгууллага болох Дэлхийн Мөрөөдлийн Сургуультай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.



Frontier Fintech Summit 2025

Монголын Финтекийн Холбооны гишүүний хувьд Frontier Fintech Summit-ийг 2 дахь жилдээ ивээн тэтгэж, бүс нутгийн хамтын ажиллагааны хэлэлцүүлэгт оролцсон.



Expat Night

Улаанбаатарт амьдарч буй гадаад иргэдэд зориулсан анхны “Expat Night” арга хэмжээгээ зохион байгууллаа. Бид харилцагчидтайгаа холбоо тогтоож, хамтдаа үнэ цэнэ бүтээхийг чухалчилдаг бөгөөд цаашид илүү олон уулзалт зохион байгуулна.



Palarong Pinoy 2025

Монгол дахь Филиппиний хамт олны уламжлалт спортын арга хэмжээг 3 дахь жилдээ дараалан дэмжиж, Pinoy Mongolia хамт олноос талархлын цом гардан авч, волейболын нөхөрсөг тоглолт хийсэн.

Оролцогч талуудын эрх ашиг

Харилцагчийн санал хүсэлт бүрийг бүртгэж, цаг алдалгүй шийдвэрлэдэг.

Харилцагчийн үйлчилгээ

117,515

харилцагчийн хандалт, хүсэлт, санал, асуудлыг 2025 онд хүлээн авсан

100%

нь бүрэн шийдвэрлэгдсэн

Харилцагчийн үйлчилгээний төв маань харилцагчдын санал хүсэлтийг утасны дуудлага, сошиал суваг болон 2 үндсэн салбараараа дамжуулан хүлээн авч, шуурхай шийдвэрлэхийн зэрэгцээ шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллийг тогтмол хүргэдэг.



Валют арилжааны салбар

osTicket систем

2025 онд харилцагчийн санал хүсэлт, гомдлыг бүртгэдэг osTicket системийг нэвтрүүлсэн. Ингэснээр хүсэлт бүрийг бүртгэж цаг алдалгүй шийдвэрлэх, үйлчилгээний чанарыг стандартчилах, гомдолд шуурхай арга хэмжээ авах, үйл ажиллагаагаа илүү ил тод, хариуцлагатай болгох боломж нэмэгдсэн.

AI ажилтан

AI ажилтан нэвтрүүлэх туршилтыг амжилттай хэрэгжүүлсэн. Туршилтын үр дүнд тулгуурлан 2026 онд системийг бүрэн нэвтрүүлэхээр бэлтгэл ажлыг үе шаттайгаар хийж байна.

sendmn

Мөнгөн гүйвуулгыг гэрлийн хурдаар

send.mn

Сэнд Эм Эн ББСБ ХХК

2025 оны үйл ажиллагааны тайлан